



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2026/006/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2026 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn Аудитын менежер: М.Нарантуяа Утас: 99029193 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК Захирал Д.Баатарсайхан Утас: 99099199 Цахим хаяг: Info@ghtaudit.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2026.02.25 № 117

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түмэнцогт сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн байдлаар байгууллагын богино хугацаат өглөг 30,923.2 мянган төгрөг, авлага 1,068.1 мянган төгрөгөөр бүртгэгдсэн бөгөөд өглөгийн хэмжээ нь авлагаас давсан байна. Энэ нь бүртгэгдсэн авлагаар өр төлбөрийг барагдуулах боломж хязгаарлагдмал, үйл ажиллагааны санхүүжилтийн хүндрэл үүсэх, улмаар иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, тасралтгүй байдлыг алдагдуулах эрсдэлийг бий болгож байна.

Гол анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын явцад санхүүгийн тайланд хамгийн их ач холбогдолтой, аудитын явцад онцгой анхаарал шаардсан, материаллаг буруу

илэрхийллийн өндөр эрсдэлтэй асуудал илрээгүй тул аудитын гол асуудал тодорхойлоогүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудиторын дүгнэлтэд өөрчлөлт оруулахгүйгээр мэдээлэхэд, тус аудитын хүрээнд санхүүгийн тайланд хавсаргасан үйл ажиллагааны тайлан, статистик мэдээлэлд аудитын баталгаа өгөөгүй бөгөөд эдгээр нь аудитын дүгнэлтийн хамрах хүрээнд хамаарахгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>194,833,671.98</u>	<u>106,835,711.01</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	205.45	5,213,546.87
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	205.45	5,213,546.87
3121	Төгрөг	205.45	5,213,546.87
31211	Төрийн сангийн харилцах	205.45	5,213,546.87
33	АВЛАГА	90,133,108.57	1,068,137.03
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	90,133,108.57	1,068,137.03
35	БАРАА МАТЕРИАЛ	104,700,357.96	100,554,027.11
351	Түүхий эд материал	49,070,367.96	51,161,587.11
35110	Тусгай зориулалттай материал	36,294,528.00	32,043,929.00
35130	Эм боох материал	12,775,839.96	19,117,658.11
354	Хангамжийн материал	32,339,990.00	28,982,440.00
35410	Бичиг хэргийн материал	-	407,500.00
35420	Аж ахуйн материал	6,101,800.00	3,940,750.00
35470	Бусад хангамжийн материал	26,238,190.00	24,634,190.00
35600	Мал амьтад	23,290,000.00	20,410,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>421,404,092.81</u>	<u>368,459,070.73</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	421,404,092.81	368,459,070.73
392	Биет хөрөнгө	374,461,842.81	325,069,570.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	199,317,280.01	199,317,280.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(63,167,199.12)	(73,695,065.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	154,000,000.00	154,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(73,055,555.50)	(93,722,222.14)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	256,924,001.69	291,601,001.69
39206	Хуримтлагдсан элэгдэл	(114,834,682.12)	(162,924,931.49)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,269,625.40	34,669,625.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,373,360.88)	(27,713,050.10)
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,457,154.23	22,457,154.23
39215	Хуримтлагдсан элэгдэл	(16,075,420.90)	(18,920,221.23)
393	Биет бус хөрөнгө	46,942,250.00	43,389,500.00
39301	Програм хангамж	27,995,000.00	27,995,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,800,750.00)	(5,353,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,748,000.00	20,748,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>616,237,764.79</u>	<u>475,294,781.74</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>81,040,752.25</u>	<u>30,923,245.10</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	81,040,752.25	30,923,245.10
413	Өглөг	81,040,752.25	30,923,245.10
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	79,094,662.25	14,171,850.10
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	11,087,495.00
4136	Бусад өглөг	1,946,090.00	5,663,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,946,090.00	5,663,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>535,197,012.54</u>	<u>444,371,536.64</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	535,197,012.54	444,371,536.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	209,622,987.00	209,622,987.00
51101	Өмч: - төрийн	209,622,987.00	209,622,987.00

512	Хуримтлагдсан үр дүн	165,282,670.19	74,457,194.29
51210	Өмнөх үеийн үр дүн	165,282,670.19	165,282,670.19
51220	Тайлант үеийн үр дүн	-	(90,825,475.90)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	160,291,355.35	160,291,355.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	616,237,764.79	475,294,781.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,133,140,597.29	1,142,942,375.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	130,800,996.40	33,817,376.15
120	Нийтлэг татварын бус орлого	130,800,996.40	33,817,376.15
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	97,040,450.40	22,921,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	33,760,546.00	10,896,376.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,002,339,600.89	1,109,124,999.59
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	65,593,699.23
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	-	65,593,699.23
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,047,400.00	75,472,932.46
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,047,400.00	75,472,932.46
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	931,292,200.89	968,058,367.90
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	931,292,200.89	968,058,367.90
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,104,332,210.62	1,233,767,851.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,104,332,210.62	1,233,767,851.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,104,153,377.36	1,171,377,851.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	703,562,185.97	750,720,138.17
210101	Үндсэн цалин	357,630,026.84	433,133,891.11
210102	Нэмэгдэл	308,365,098.85	271,676,027.06
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,822,000.00	23,565,000.00
210104	Урамшуулал	32,745,060.28	22,345,220.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,390,734.68	93,476,131.03
210201	Тэтгэврийн даатгал	60,756,485.85	64,994,261.60
210202	Тэтгэмжийн даатгал	7,147,821.91	7,646,383.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,527,710.96	3,753,891.93
210204	Ажилгүйдлийн даатгал	3,391,743.22	3,416,318.54
210205	Эрүүл мэндийн даатгал	13,566,972.74	13,665,275.21
2103	Байр ашиглалтын тогтмол зардал	66,868,566.74	70,472,932.46
210301	Гэрэл, цахилгаан	5,789,526.74	7,338,260.75
210302	Түлш, халаалт	59,125,440.00	59,125,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,953,600.00	4,009,271.71
2104	Хангамж, бараа материалын зардал	34,032,200.00	33,765,101.00
210401	Бичиг хэрэг	2,071,100.00	2,779,700.00
210402	Тээвэр, шатахуун	25,885,300.00	24,619,501.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,425,800.00	4,715,900.00

2105	Нормативт зардал	90,637,950.75	89,814,416.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,260,171.75	75,745,959.20
210502	Хоол, хүнс	13,377,779.00	14,068,457.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,744,920.00	12,353,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	12,353,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,298,000.00	3,260,000.00
210702	Дотоод албан томилолт	3,298,000.00	3,260,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,723,280.00	13,238,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,723,280.00	11,780,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,008,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,895,539.22	104,278,132.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,029,039.00	15,256,110.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83,866,500.22	89,022,022.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	178,833.26	62,390,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	62,390,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад үзүүлэх дэмжлэг	-	60,390,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	178,833.26	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	178,833.26	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>28,808,386.67</u>	<u>(90,825,475.90)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>28,808,386.67</u>	<u>(90,825,475.90)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>927,366,371.32</u>	<u>1,198,189,971.13</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>927,366,371.32</u>	<u>1,198,189,971.13</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	65,593,699.23
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого	-	65,593,699.23
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,047,400.00	75,472,932.46
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,047,400.00	75,472,932.46
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	856,318,971.32	1,057,123,339.44
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	856,318,971.32	1,057,123,339.44
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<u>925,224,155.22</u>	<u>1,184,645,629.71</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>925,224,155.22</u>	<u>1,184,645,629.71</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>925,045,321.96</u>	<u>1,122,255,629.71</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	638,945,655.22	805,339,566.65
210101	Үндсэн цалин	293,057,265.81	414,558,228.67
210102	Нэмэгдэл	308,321,329.13	345,027,097.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,822,000.00	23,446,589.88
210104	Урамшуулал	32,745,060.28	22,307,650.78

2102	Ажил олгогчоос төлөх НД шимтгэл	78,312,000.00	103,779,514.70
210201	Тэтгэврийн даатгал	53,252,200.00	72,742,630.36
210202	Тэтгэмжийн даатгал	6,265,000.00	8,524,347.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,132,300.00	4,146,873.65
210204	Ажилгүйдлийн даатгал	3,132,300.00	3,673,332.52
210205	Эрүүл мэндийн даатгал	12,530,200.00	14,692,330.99
2103	Байр ашиглалтын тогтмол зардал	66,868,566.74	70,472,932.46
210301	Гэрэл, цахилгаан	5,789,526.74	7,338,260.75
210302	Түлш, халаалт	59,125,440.00	59,125,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,953,600.00	4,009,271.71
2104	Хангамж, бараа материалын зардал	27,385,200.00	32,776,701.00
210401	Бичиг хэрэг	2,071,100.00	3,307,200.00
210402	Тээвэр, шатахуун	19,021,300.00	24,619,501.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,650,000.00	1,650,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,642,800.00	3,200,000.00
2105	Нормативт зардал	94,608,300.00	80,254,854.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	78,189,201.00	70,005,232.20
210502	Хоол, хүнс	11,419,099.00	8,249,622.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,774,920.00	12,963,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	744,920.00	2,970,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	9,993,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,298,000.00	3,020,000.00
210702	Дотоод албан томилолт	3,298,000.00	3,020,000.00
2108	БГАҮТ хураамж	2,680,780.00	3,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,680,780.00	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,171,900.00	10,649,060.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,171,900.00	10,649,060.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	178,833.26	62,390,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	62,390,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	60,390,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	178,833.26	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	178,833.26	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,142,216.10	13,544,341.42
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,200,000.00	10,466,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,200,000.00	10,466,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,200,000.00	10,466,000.00
225106	Биет хөрөнгө худалдан авсан зардал	2,200,000.00	10,466,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(2,200,000.00)	(10,466,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(57,783.90)	3,078,341.42
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		205.45
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	205.45	5,213,546.87

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	209,622,987.00	160,291,355.35	165,282,670.19	535,197,012.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	209,622,987.00	160,291,355.35	165,282,670.19	535,197,012.54
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(90,825,475.90)	(90,825,475.90)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,622,987.00	160,291,355.35	74,457,194.29	444,371,536.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,301,243,700.00	1,195,111,629.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,301,243,700.00	1,184,645,629.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,238,853,700.00	1,122,255,629.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	862,872,500.00	805,339,566.65
210101	Үндсэн цалин	413,298,800.00	414,558,228.67
210102	Нэмэгдэл	395,513,700.00	345,027,097.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,060,000.00	23,446,589.88
210104	Урамшуулал	30,000,000.00	22,307,650.78
2102	Ажил олгогчоос төлөх НД шимтгэл	112,575,300.00	103,779,514.70
210201	Тэтгэврийн даатгал	76,474,000.00	72,742,630.36
210202	Тэтгэмжийн даатгал	7,826,700.00	8,524,347.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,181,600.00	4,146,873.65
210204	Ажилгүйдлийн даатгал	2,292,800.00	3,673,332.52
210205	Эрүүл мэндийн даатгал	17,800,200.00	14,692,330.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,515,500.00	70,472,932.46
210301	Гэрэл, цахилгаан	7,000,000.00	7,338,260.75
210302	Түлш, халаалт	59,125,400.00	59,125,400.00
210303	Цэвэр, бохир ус	9,390,100.00	4,009,271.71
2104	Хангамж, бараа материалын зардал	40,047,600.00	32,776,701.00
210401	Бичиг хэрэг	3,597,600.00	3,307,200.00
210402	Тээвэр, шатахуун	30,000,000.00	24,619,501.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,650,000.00	1,650,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	4,800,000.00	3,200,000.00
2105	Нормативт зардал	95,223,600.00	80,254,854.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,223,600.00	70,005,232.20
210502	Хоол, хүнс	18,000,000.00	8,249,622.70
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,833,900.00	12,963,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,973,900.00	2,970,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,993,000.00
2107	Томилот, зочны зардал	4,800,000.00	3,020,000.00

210702	Дотоод албан томилолт	4,800,000.00	3,020,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,140,000.00	3,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,140,000.00	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,845,300.00	10,649,060.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,845,300.00	10,649,060.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,390,000.00	62,390,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,390,000.00	62,390,000.00
213208	Хөдөө орон нутагт ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	60,390,000.00	60,390,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	10,466,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	10,466,000.00
223001	Бусад хөрөнгө	-	10,466,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,301,243,700.00	1,198,189,971.13
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	65,593,700.00	65,593,699.23
131105	төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	65,593,700.00	65,593,699.23
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	80,515,500.00	75,472,932.46
132001	Орон нутгийн төсвөөс	80,515,500.00	75,472,932.46
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,155,134,500.00	1,057,123,339.44
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,155,134,500.00	1,057,123,339.44
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	205.45
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,213,546.87
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29.00	20.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	6,300.00	7,238.00
640002	Улсын эмнэлгийн амбулаториор эмчлүүлэгсдийн тоо	6,000.00	6,832.00
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо	300.00	406.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29.00	20.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	24.00	15.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.00

Гурав . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар 18,142.8 мянган төгрөгийн нийт 6 алдаа илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд:

- *НДШ болон ХХОАТ-ын өглөгийн дансны харьцаа, журналын бичилтийг дутуу хийж, зардлын данс руу хаасан нь ажил гүйлгээний иж бүрэн байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй.*

- *Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 5,096.0 мянган төгрөгийн хөрөнгийг АА-н материалд орлого авч урсгал засварын зардалд тайлагнасан, ангилал буруу бүртгэсэн нь ангилал батламж мэдээдлийг хангаагүй. Эдгээр алдааг санхүүгийн тайланд залруулсан.*

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үлдэх өртөггүй 137 нэр төрлийн 217ш хөрөнгө бүртгэлтэй байгаа боловч дахин ашиглагдах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үлдэх өртгийг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж, дахин ашиглагдах боломжтой, үлдэх өртөггүй бүртгэлтэй 137 нэр төрлийн 217 ширхэг хөрөнгийн ашиглалтын хугацаа, үлдэх өртгийг бодит нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэн тогтоолгох асуудлыг орон нутгийн өмчийн газарт уламжлан шийдвэрлүүлэх, шаардлагатай тохиолдолд элэгдлийн тооцооллыг УСНББОУС 17 болон УСНББОУС 3-т заасны дагуу өөрчлөн бүртгэж, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах арга хэмжээ авах.

2. Зардалын данстай холбоотой

Илрүүлэлт: Цахим төлбөрийн баримтаар үүссэн нэхэмжлэл, төлбөрийн баримтыг тулган шалгахгүй гүйлгээ хийсний улмаас байгууллагаас ибаримт аваагүй, зарим байгууллагаас нэхэмжлэл, төлбөрийн баримтаар давхардуулан баримт авсан байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу төлбөрийг төлсний дараа тухайн байгууллагаасаа нэхэмжлэхийг хаалгаж төлбөрийн баримтыг авах.

3. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны эцэст 30,923.2 мянган төгрөгийн өглөг, 1,068.1 мянган төгрөгийн авлага тайлагнасан бөгөөд авлага, өглөгийн зохистой харьцаа алдагдсан байна. Үүссэн өр төлбөрийг барагдуулахад гүйцэтгэлийн санхүүжилт хүрэлцэхгүй, өрийг хэрхэн барагдуулах төлөвлөгөө тодорхойгүй байгаа нь санхүүгийн хүндрэл үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж, цаашлаад иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг тасралтгүй, хүртээмжтэй хүргэх чиг үүрэгт сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдэж байна.

Өгсөн зөвлөмж: Өр, авлагын харьцааг оновчтой түвшинд хүргэх зорилгоор авлага барагдуулах, өглөг бууруулах төлөвлөгөөг үе шаттай боловсруулж хэрэгжүүлэх, зардлын бүтэц, гүйцэтгэлийн санхүүжилтийн уялдааг нарийвчлан тооцож санхүүгийн сахилга бат, дотоод хяналтыг сайжруулах, шаардлагатай тохиолдолд дээд шатны байгууллагад санхүүжилтийн эх үүсвэрийн зохицуулалтын санал хүргүүлж, өр төлбөрийн удирдлагыг тогтмол хянах механизмыг бүрдүүлэх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төв	3	17,781.0			3	17,781.0	3	17,781.0	-	-	-	-
Дүн	3	17,781.0	-	-	3	17,781.0	3	17,781.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төв	2	361.8					2	361.8	-	-	-	-
Дүн	2	361.8	-	-	-	-	2	361.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төв	1				1			
Дүн	1		-	-	-	1		

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
НИЙТ			1	-	-	1	-	-	-